

АРБИТРААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

Монголын Олон Улсын Арбитрын Арбитрч,
ОТИС-ийн ХЗС-ийн багш, доктор (Ph.D) М.Сувд

Хураангуй: *Арбитрын тухай Монгол Улсын хуулийн үзэл баримтлал нь 2006 онд нэмэлт өөрчлөлт орсон НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрх зүйн Комиссын загвар хуулийн үзэл баримтлалд нийцжээ. Үүний үр дүнд Монгол Улс уг загвар хуулийн үзэл баримтлалыг үндэсний хуульдаа тусган хэрэгжүүлж байгаа улсын жагсаалтад бүртгэгдсэн болно.*

Abstract: *Mongolian arbitration law's concept based on the UNCITRAL Model Law on International Commercial Arbitration (1985), with amendments as adopted in 2006. As a result Mongolia registered that a country national legislation based on the Model law has been adopted.*

Арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, эрх зүйн шинэтгэлийн асуудлыг хөндөхийн өмнө арбитрын эрх зүйн статусын талаарх эрдэмтэд, судлаачдын зарим үзэл баримтлалыг товч дурдах нь зохистой.

Улс хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник эрчимтэй хөгжиж байгаа орчин үед иргэний хэргийг арбитрын журмаар хянан шийдвэрлэх асуудал чухал болж байна. Маргалдагч талууд гэрээ байгуулахдаа арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх нь шүүхийн журмаар шийдвэрлүүлснээс илүү ач холбогдолтой гэх үзэл олон улсын практикт нэмэгдэж байгаа нь арбитраар шийдвэрлэсэн хэргийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай холбоотой юм.

Аж ахуйн харилцаанд оролцогчид маргаан гаргахгүйгээр харилцан зөвшилцөлд хүрч эвлэрэлийн журмаар асуудлыг шийдэх боломжгүйд хүрдэг нь олон улсын практикаас харагдаж байгааг үгүйсгэх боломжгүй. Иймд харилцан тохиролцсон гэрээний үүргийг биелүүлэх үүднээс маргаанаа шийдвэрлүүлэхээр арбитрарт ханддаг. Маргалдагч талууд харилцан тохиролцож байгуулсан гэрээ, хэлэлцээртээ хэрэв маргаан гарвал маргаанаа арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай урьдчилан заах буюу маргааны дараа харилцан тохиролцсон байдаг нь арбитрарт хандах хууль зүйн үндэслэл нь болдог онцлогтой.

Эрдэмтэд, судлаачдын дунд арбитр нь шүүх мөн, эсэх талаар маргаантай. ОХУ-ын эрдэмтэн М.М.Богуславский “арбитр бол талууд өөр хоорондын маргаанаа шийдвэрлүүлэхээр сонгож авсан хөндлөнгийн шүүх юм, мөн улсын эрдэмтэн

А.С.Скаридов “арбитр нь маргааныг хянан шийдвэрлэж дуусгах хөндлөнгийн шүүх” гэсэн нь арбитрыг хөндлөнгийн шүүх гэсэн үзэл баримтлал юм. Зарим хуульч эрдэмтэд арбитрыг шүүх биш гэж үздэг бөгөөд энэ чиглэлийн үзэл баримтлал давамгайлдаг. Арбитрыг шүүх мөн эсэхийг нотлох нь төдийлөн ач холбогдолгүй байх талтай. Энэ нь арбитрын байгууллагын эрх зүйн статус, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогтой уялдуулан арбитрыг шүүхийн ижил төстэй ба ялгаатай байдлыг харьцуулан судлах нь зохистой. Арбитр нь мөн чанарын хувьд шүүхтэй ижил төсөөтэй, талуудын тохиролцоонд хүрч чадахгүй байгаа маргааныг нэг мөр эцэслэн шийдвэрлэдэг өвөрмөц чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд засаглал хуваах онолын хувьд арбитр нь шүүх биш болох нь нотлогддог.

Арбитр нь гэрээний талууд хоорондын маргааныг арбитрын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий байгууллага гэдэг нь түүний харьяалан шийдвэрлэх маргааныг хуульчилсантай холбоотой. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ” хэмээн хуульчилсан.

Монгол Улсад 2003 оны арбитрын тухай хуульд байнгын арбитрыг худалдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж болох бөгөөд уг арбитрыг байгуулах тухай шийдвэр гаргаж, арбитрчдын нэрсийн жагсаалт баталснаар байнгын арбитр байгуулагдсанд тооцно. Харин төрийн захиргааны байгууллага, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, ашгийн төлөө хуулийн этгээдийн дэргэд арбитр байгуулахыг хориглосон хэм хэмжээ үйлчилж байв. Энэхүү эрх зүйн зохицуулалтыг үндэслэн арбитрыг төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг, ашгийн төлөө бус хуулийн этгээд хэмээн арбитраар хэрэг хянан шийдвэрлэх тухай дүрэмд тусгаж байсан болно.

Одоогийн дагаж мөрдөж буй арбитрын тухай хуульд Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно, байнгын арбитр нь арбитрын ажиллагааг явуулах байр, хүний нөөцтэй байна хэмээн байнгын

арбитрыг ашгийн бус байгууллагын дэргэд байгуулахыг илүү нээлттэй болгон хуульчилсан онцлогтой.

Арбитрын эрх зүйн статусыг гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж үзэхэд ихэнх улсад байнгын арбитрыг худалдаа аж үйлдвэрийн танхим болон өөр байгууллагын дэргэд байгуулдаг бол зарим улсад байнгын арбитрыг бие даасан хуулийн этгээдийн статустай байгуулдаг байна. Жишээ нь: Байнгын арбитрыг Армен Улсад худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөрөнгийн бирж, Армены банк болон бусад байгууллагын холбооны дэргэд үүсгэн байгуулдаг туршлагатай байна. Солонгос, Польш, Перу, Беларусь, Венесуэль, Литва, ОХУ, Франц, Гондурис, Энэтхэг, Бахрэйн, Лебанон, Арабын нэгдсэн Эмират улс, Катар зэрэг орнуудад мөн худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд, ХБНГУ, Индонези, Итали, Нидерланд, АНУ, Авсртали, Англи, Бразил, Канад, Шинэ Зеланд, Малайз, Мексик, Египет гэх мэт орнуудад уг танхимын дэргэд байгуулдаггүй байна. Цаашид арбитр бол бие даасан институт болж хөгжих асуудлыг судлах шаардлагатай.

Ер нь арбитрын тухай Монгол Улсын хуулийг батлах олон улсын болон үндэсний эрх зүйн, практик шаардлага байсан гэж болно. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн А/61/453 тоот тогтоолд “олон улсын арилжааны арбитрын ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг ижилтгэх зорилгоор НҮБ-ын олон улсын худалдааны эрх зүйн комисс (ЮНСИТРАЛ)-ын загвар хууль (цаашид “загвар хууль” гэх)-ийн нэмэлт, өөрчлөлт оруулсан зүйл, заалтыг, эсхүл нэмэлт, өөрчлөлт орсон загвар хуулийг бүхэлд нь нутагшуулах талаар бүх гишүүн улсууд анхаарал хандуулах, үндэсний хууль батлах, эсхүл шинэчлэн батлах” гэж тусгасан нь уг хуулийг батлах олон улсын эрх зүйн үндэслэл мөн. 2003 онд батлагдсан арбитрын тухай хуулийг загвар хуулийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан гэх боловч Монгол Улс өнөөг хүртэл загвар хуулийн үзэл санааг үндэсний хуульдаа тусган хэрэгжүүлж байгаа улсын жагсаалтад бүртгэгдээгүй байв.

Судалгаанд үндэслэвэл иргэний хэргийн анхан шатны шүүхээр 2014 онд 33996 хэрэг, 2015 онд 40674 хэрэг, 2016 онд 33254 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч хэргийг хянан шийдвэрлэсэн бол Монголын олон улсын ба үндэсний арбитраг 2014 онд 31 хэрэг, 2015 онд 24 хэрэг, 2016 онд Монголын Олон улсын ба Үндэсний Арбитраар нийт 100 нэхэмжлэл хүлээн авснаас 46 хэргийг шийдвэрлэсэн статистикийн судалгаа бий.

Үүний 30 орчим хэрэгт арбитрын ажиллагаа явуулсан ба 74 хэргийг эцэслэн шийдвэрлэж арбитрын үндсэн шийдвэр гаргасан ажээ. Эдгээр хэргийн 10 хэрэгт талууд эвлэрэн хэлэлцэж эвлэрлийн гэрээг баталгаажуулсан ба 7 хэргийн нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзан арбитрын ажиллагааг тус тус дуусгавар болгосон байна. Маргааны талуудын 87 хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, 13 хувь нь БНХАУ, ОХУ, Вьетнам, БНСУ, Сингапур, Англи, ХБНГУ байх бөгөөд хэргийн 32 хувь нь ажил гүйцэтгэх гэрээ, 28 хувь нь худалдах, худалдан авах гэрээ, 40 хувь нь үйлчилгээ үзүүлэх, даатгал, зээл, түрээсийн гэрээний маргаан байна. Эдгээр судалгаа бол арбитрын харьяаллын маргааныг өргөжүүлэх замаар шүүхийн ачааллыг хөнгөвчлөх практикийн хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байна гэж болно.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын 80 орчим хуульд шүүхийн онцгой харьяалал тогтоон маргааныг зөвхөн шүүхээр шийдвэрлүүлэхээр хуульчилсан нь маргааныг арбитраар шийдвэрлэх боломжийг хязгаарласан эрх зүйн зохицуулалт гэх үндэслэлтэй байв.

Арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн шинэтгэлийг илэрхийлэхэд 2003 ба 2017 оны арбитрын тухай Монгол Улсын хуулийн үндсэн зохицуулалтыг харьцуулан судлах нь зүйтэй гэж үзэв.

АРБИТРЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

№	Шалгуур үзүүлэлт	Арбитрын тухай Монгол Улсын хууль (2003 он)	Арбитрын тухай Монгол Улсын хууль (2017 он)
1	Хуулийн зорилт	1.1.Эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулах.	1.1.Эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулах.
2	Хуулийн үйлчлэх хүрээ	3.1.Маргаан шийдвэрлэх арбитр нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулах тохиолдолд энэ хууль үйлчилнэ.	2.1.Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс бол энэ хууль үйлчилнэ.
3	Арбитрын төрөл, түүнийг байгуулах	5.1.Арбитр нь байнгын болон түр хэлбэртэй байна. 5.2.Байнгын арбитрыг худалдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж болно.	7.1.Арбитр нь байнгын, эсхүл түр байж болно. 7.3.Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно.

4	Арбитрын харьяаллын маргаан	6.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан арбитрын харьяалалд хамаарна.	9.1.Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.
5	Арбитрын харьяалалд үл хамаарах маргаан	7 дугаар зүйл	Зохицуулалтгүй
6	Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо	8 дугаар зүйл Арбитрын ажиллагаа явагдаж байгаа газрын давж заалдах шатны шүүх шийдвэрлэх ба шүүх хуульд тусгайлан зааснаас бусад маргаанаар арбитрын ажиллагаанд оролцож үл болно.	6 дугаар зүйл Хуульд заасан шүүхийн чиг үүргийг арбитрын ажиллагаа явагдсан газрын иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, харин олон улсын арбитрын ажиллагааны хувьд нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэрэгжүүлэхээр хуульчилсан.
7	Баримт бичиг хүргүүлэх	9 дүгээр зүйл Талууд өөрөөр тохиролцоогүй бол баримт бичгийг хүлээн авагч талд биеэр, эсхүл шуудангийн баталгаат илгээмжээр хүргүүлнэ.	4 дүгээр зүйл Баримт бичгийг хүргэсэн өдрийг түүнийг хүлээн авсан өдөр гэж үзэх, хуульд заасан аргаар илгээснээр баримт бичгийг хүргэсэнд тооцохыг хуульчилсан.
8	Арбитрын ажиллагаа	Зохицуулалтгүй	3 дугаар зүйл Арбитрын ажиллагаа гэдэгт байнгын, эсхүл түр арбитраас явуулж байгаа олон улсын ба дотоодын арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг ойлгох тухай шинэ зохицуулалттай болсон.
9	Арбитрын хэлэлцээрийн ойлголт, хэлбэр	11 дүгээр зүйл Арбитрын хэлэлцээр гэж ... талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ.	8 дугаар зүйл Арбитрын хэлэлцээрийн гэж ... талуудын тохиролцоог хэлнэ. Өмнө үйлчилж байсан хуулийн зохицуулалттай үндсэндээ ижил
10	Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг шүүх баталгаажуулах	13 дугаар зүйл 13.1.Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө буюу арбитрын ажиллагааны явцад талууд арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулахаар анхан шатны шүүхэд хүсэлт гаргаж болох бөгөөд шүүгч уг хүсэлтийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авч болох ба үүнийг арбитрын хэлэлцээртэй зөрчилдсөн гэж үзэхгүй.	11 дүгээр зүйл 11.1.Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл уг ажиллагааны явцад арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах энэ хуулийн 19.2-т заасан арга хэмжээ авахуулахаар шүүхэд хүсэлт гаргасан, шүүх уг хүсэлтийг хангасан шийдвэр гаргасан нь арбитрын хэлэлцээрийг зөрчсөнд тооцогдохгүй.
	Арбитраас гарах шийдвэрийн	21 дүгээр зүйл 21.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд арбитрын бүрэлдэхүүн тухайн	19 дүгээр зүйл Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрын

11	биелэлтийг арбитрын бүрэлдэхүүн баталгаажуул ах	маргааны хувьд шаардлагатай гэж үзвэл аль нэг талын хүсэлтийг үндэслэн арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор зохих арга хэмжээ авахыг талуудад үүрэг болгож болно.		бүрэлдэхүүн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ авах, түр арга хэмжээний төрөл, хэлбэрийн талаарх шинэлэг зохицуулалттай болсон.
12	Түр арга хэмжээ авах нөхцөл	Зохицуулалтгүй		20 дугаар зүйл
13	Урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл, урьдчилсан тогтоол гаргах	Зохицуулалтгүй		21 дүгээр зүйл Түр арга хэмжээ авах тухай арбитрын бүрэлдэхүүн урьдчилсан тогтоол гаргаж болох хэм хэмжээ тусгасан.
14	Урьдчилсан тогтоол гаргах журам	Зохицуулалтгүй		22 дугаар зүйл
15	Түр арга хэмжээ, урьдчилсан тогтоолыг өөрчлөх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох	Зохицуулалтгүй	23 дугаар зүйл 23.1.Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын өргөдлөөр, онцгой тохиолдолд талуудад мэдэгдсэний үндсэн дээр өмнө нь гаргасан шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээ, эсхүл урьдчилсан тогтоолыг санаачилгаараа өөрчилж, түдгэлзүүлж, дуусгавар болгож болно.	
16	Санхүүгийн баталгаа гаргуулах	Зохицуулалтгүй	24 дүгээр зүйл 24.1.Арбитрын бүрэлдэхүүн нь түр арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан талд уг арга хэмжээтэй холбогдуулан зохих санхүүгийн баталгаа гаргахыг шаардаж болно. 24.2.Арбитрын бүрэлдэхүүн зохимжгүй, эсхүл шаардлагагүй гэж үзсэнээс бусад тохиолдолд урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан талаас уг тогтоолтой холбогдуулан санхүүгийн баталгаа гаргахыг шаардана.	
17	Мэдээллийг ил болгох	Зохицуулалтгүй		25 дугаар зүйл
18	Зардал, хохиролыг гаргуулах	Зохицуулалтгүй		26 дугаар зүйл
19	Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх	Зохицуулалтгүй		27 дугаар зүйл
20	Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч,	Зохицуулалтгүй		28 дугаар зүйл Шүүх хуульд заасан үндэслэлээр түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхээс татгалзаж болох

	гүйцэтгэхээс татгалзах үндэслэл		асуудлыг хуульчилсан.
21	Шүүхээс авах түр арга хэмжээ	Зохицуулалтгүй	29 дүгээр зүйл Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс мөн эсэхээс үл хамааран арбитрын ажиллагаатай холбоотой асуудлыг хянан шийдвэрлэхдээ шүүх түр арга хэмжээ авч болно. Шүүх энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ олон улсын арбитрын ажиллагааны онцлогийг харгалзан үзнэ.
22	Арбитрын ажиллагаа явуулах газар	24 дүгээр зүйл. Арбитрын ажиллагаа явуулах газар 24.1.Арбитрын ажиллагаа явуулах газрыг талууд харилцан тохиролцоно. 24.2.Арбитрын ажиллагаа явуулах газрыг талууд харилцан тохиролцоогүй бол маргааны нөхцөл байдлыг харгалзан арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагаа явуулах газраа тодорхойлно. 24.3.Талууд өөрөөр тохиролцоогүй бол шаардлагатай тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөх, гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг шалгалт хийх зэрэг ажиллагааг арбитрын ажиллагаа явуулах газраас өөр газар явуулж болно.	32 дугаар зүйл. Арбитрын ажиллагааны харьяалал 32.1.Арбитрын ажиллагааны харьяаллыг талууд тохиролцон тогтоох эрхтэй. Ийнхүү тохиролцон тогтоогоогүй бол арбитрын бүрэлдэхүүн талуудад чирэгдэлгүй байх зэрэг хэргийн нөхцөл байдлыг харгалзан арбитрын ажиллагааны харьяаллыг тодорхойлно. 32.2.Энэ хуулийн 32.1-д заасныг үл харгалзан, талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд арбитрын бүрэлдэхүүн зохистой гэж үзсэн бол арбитрын бүрэлдэхүүн уулзаж зөвлөлдөх, гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг хийх зэрэг ажиллагааг хаана ч явуулж болно.
23	Арбитрын ажиллагаа эхлэх	25 дугаар зүйл 25.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хариуцагч тал хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ.	33 дугаар зүйл 33.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ.
24	Нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргах	28 дугаар зүйл	36 дугаар зүйл
25	Бусдаас тусламж авах	31 дүгээр зүйл	Зохицуулалтгүй
26	Нууц хадгалах	32 дугаар зүйл	50 дугаар зүйл
27	Нотлох баримт бүрдүүлэхэд шүүх туслалцаа	33 дугаар зүйл	39 дүгээр зүйл

	үзүүлэх		
28	Арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэх	42 дугаар зүйл	Зохицуулалтгүй
29	Арбитрын шийдвэр	35 дугаар зүйл	42 дугаар зүйл
30	Талууд эвлэрэх	36 дугаар зүйл	43 дугаар зүйл
31	Арбитрын шийдвэрийн хэлбэр, агуулга	37 дугаар зүйл	44 дүгээр зүйл
32	Арбитрын ажиллагаа дуусгавар болох	38 дугаар зүйл	45 дугаар зүйл
33	Арбитрын шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах	39 дүгээр зүйл	46 дугаар зүйл
34	Шийдвэр хүчингүй болгох тухай	40 дүгээр зүйл	47 дугаар зүйл
35	Арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэхээс татгалзах	43 дугаар зүйл	48, 49 дүгээр зүйл
36	Дампуурал	Зохицуулалтгүй	51 дүгээр зүйл

Дээрх харьцуулсан судалгаанд үндэслэн дараах дүгнэлтэнд хүрэв. Үүнд:

1. 2017 онд батлагдсан арбитрын тухай хуулийн үндсэн үзэл баримтлал бол 2003 онд батлагдан үйлчилж байсан арбитрын тухай хуулийн дэвшилтэт зохицуулалтыг хадгалсан, гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцийн дагуу Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.
2. 2006 онд нэмэлт, өөрчлөлт орсон загвар хуулийн үзэл баримтлалыг үндэсний хуулиндаа тусгасан орны тоонд бүртгэгдсэн тухай судалгаа бол арбитрын тухай Монгол Улсын хууль нь олон улсын жишигт нийцэхүйц үзэл баримтлалтай гэх үндэслэлтэй байна.

3. Арбитраар хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдох харилцааг олон улсын стандартад (загвар хуулийн) нийцүүлэн зохицуулахыг уг хуулийн зорилт болгожээ.
4. Арбитрын хэлэлцээр, түүнийг байгуулсанд тооцох харилцааг шинжлэх ухаан, техник технологийн хөгжилтэй уялдуулан нарийчлан хуульчилсан нь арбитрын харьяалалын маргааныг өргөтгөх хууль зүйн нөхцлийг бүрдүүлжээ гэж болно.
5. Хуульд арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах талаарх арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхийн хүрээнд арбитрын бүрэлдэхүүн түр арга хэмжээ авах нөхцөл, үүнтэй холбогдон урьдчилсан тогтоол гарган журамлах, түр арга хэмжээний биелэлтийг хангах болон шүүхээс авах түр арга хэмжээ гэх мэт шинэлэг зохицуулалтыг бий болгосон нь дэвшилттэй юм.
6. Арбитрын тухай Монгол Улсын хуулийн бас нэгэн дэвшилтэт тал бол уг хуулийг дагаж нэмэлт өөрчлөлт оруулсан холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан зүйлүүд нь шүүхийн ачааллыг бууруулах замаар арбитрын харьяаллын маргааныг өргөтгөхөд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал мөн.
7. Арбитрын тухай Монгол Улсын хууль олон улс жишигт нийцэхүйц үзэл баримтлалтай болсноор гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засгийн ач холбогдолтой байх магадлалтай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Арбитрын тухай хууль, 2003, 2017
2. Арбитрын тухай Монгол Улсын хуулийн төслийн үзэл баримтлал
3. М.М.Богуславский, Олон улсын хувийн эрх зүй, 2008, 442 дахь тал
4. А.С.Скаридов, Международное частное право, Санкт-Петербург, 1998 г, стр 610
5. М.Сувд, Ц.Ундрах, О.Хишигмөнх, Олон улсын эрх зүй, хамтын бүтээл, Уб хот, 2012, 210 дахь тал
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
7. Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2012, 533 дахь тал
8. The *Law Of the Republic Of Armenia On Arbitration Courts and Arbitration Procedures*, article 2
9. <https://www.uncitral.org/pdf/english/texts/arbitration/NY-conv/a61-33-e.pdf>
10. http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/1985Model_arbitration_status.html

Хууль Сахиулахын Их Сургууль,
“Эрх зүйн процесс – Эрх зүйн шинэтгэл”
ЭШБХ-ын баримт бичиг, 2017, №